МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 12 өдөр Дугаар А/159 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2.1, 18.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оныг Хөвсгөлд зочлох жил болгон зарласантай холбогдуулан аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөний ажлын хүрээнд "Улаанбаатар Травел Экспо 2022" үзэсгэлэнд оролцох бэлтгэл ажлыг хангаж, нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

2. Үзэсгэлэнд оролцох агуулгыг тодорхойлж ажлын төлөвлөгөө болон санхүүгийн тооцооллыг боловсруулж 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

3. "Улаанбаатар Травел Экспо 2022" үзэсгэлэнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгж байгууллага, бизнес эрхлэгчид, гар урлал, нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг өргөнөөр хамруулж, орон нутгийн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, соёлын өв, байгалийн болон түүхийн аялал жуулчлалын талаар сурталчлан үр дүнтэй оролцохыг ажлын хэсэг (П.Мөнхжаргал)-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 05
дугаар сарын 12 -ний өдрийн А/159
дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Мөнхжаргал	(Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Б.Оюунтуяа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
Ж.Даваадамдин	(Соёл, урлагийн газрын дарга)
Б.Банзрагч	(Аймгийн ХДТ-н даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Ё.Батсайхан	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн)
П.Эрдэнэ-Уул	(Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний холбооны тэргүүн)
Я.Отгонбаяр	(Хөвсгөлийн Аялал жуулчлал эрхлэгчдийн холбооны тэргүүн)
Д.Дуламсүрэн	(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Аялал жуулчлалын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Оргилбаатар	(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлалын мэргэжилтэн)

_____oOo_____